



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 1d өдөр

Дугаар №248

Мандалговь

Г Ёс зүйн зөвлөл байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, байгууллагын хамт олны 2022 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг 5 гишүүнтэй байхаар тогтоож, дараах бүрэлдэхүүнтэй 3 жилийн хугацаатайгаар томилсугай.

Зөвлөлийн дарга: Л.Баярсайхан(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Даариймаа(Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч )  
Г.Энхтайван (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Г.Цэрэндолгор (Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер)  
Б.Адъяа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн гадаад харилцааны мэргэжилтэн )

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга (Л.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

48.2150635